

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ УЛИРЛЫН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

2024 оны 04 дүгээр сарын 19

Номгон

Баянхонгор аймгийн 2024 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 25 нэр төрлийн 93,7 тэрбум, урсгал төсвөөр 2 нэр төрлийн 47.8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 92 нэр төрлийн 20,0 тэрбум төгрөгийн, нийт 119 нэр төрлийн 113,7 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.

2024 оны эхний улирлын байдлаар холбогдох сумуудад 4,2 тэрбум төгрөгийн 23 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 нэр төрлийн 38,0 тэрбум, урсгал төсвөөр 2 нэр төрлийн 47,8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 7.7 тэрбум төгрөгийн 33 төсөл арга хэмжээ, нийт 47 нэр төрлийн 45,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгосон төлөвлөгөө 60%-ийн биелэлттэй явагдаж байна.

Дээрх нийт тендер нь зарлагдсан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 82,8 сая төгрөг, орон нутгийн төсвийн батлагдсан хөрөнгө оруулалтаас 121,4 сая төгрөг, нийт 204,2 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг гарган ажиллаа. Тайлант хугацаанд зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний явцыг одоогийн байдлаар нь ангилвал:

- 🚩 Тендер нь зарлагдсан 15 буюу 31.6 тэрбум төгрөг-31.2%
- 🚩 Гэрээ байгуулагдсан -20 буюу 10.2 тэрбум төгрөг-41.6%
- 🚩 Үнэлгээний шатандаа яваа-10 буюу 7.6 тэрбум төгрөг-20.8%
- 🚩 Тендер нь дахин зарлагдах-2 буюу 236.0 сая төгрөг-4.1%
- 🚩 Тендер нь зарлагдаагүй буюу ажлын даалгавар, ТЭЗҮ ирүүлээгүй төсөл арга хэмжээ-49 буюу 60,5 тэрбум төгрөг-41.3% тус тус байна.

(Хүснэгтээр гаргасан тайланг хавсаргав)

Мэдээлэл бэлтгэсэн мэргэжилтэн С.Рэнцэнбямба Утас:88295091. Мейл хаяг:

renstenbymba@yahoo.com

_____оОо_____